



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 12 өдөр

Дугаар А/654


Хэрлэн сум

Үзлэг оношилгоонд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны хоёрдугаар хуралдааны “Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 06 дугаар тогтоол, 2024 оны 06 дугаар сарын 07-ны “Аймгийн 2024 оны Төсөвт өөрчлөлт оруулах тухай” хорин долоодугаар Хуралдааны 08 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- 1.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Зонхилон тохиолдох хавдрыг эрт илрүүлэх үзлэг, шинжилгээг” зохион байгуулахад 4,300,000 (дөрвөн сая гурван зуун мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.
- 2.Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.
- 3.Шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Н.Үнэнбат)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Зоригтбаатар)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.АЮУРБУНЬ

Аймгийн Засаг даргын 2024 оны
12 дугаар сарын 12-ны өдрийн
А/б.с.д. дугаар захирамжийн хавсралт

Хөрөнгө зарцуулалтын тооцоо

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Нийт үнэ
1.	Хоолны зардал	Төгрөг	2,200,000
2.	Буудлын зардал	Төгрөг	2,100,000
НИЙТ			4,300,000